



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 14 өдөр

Дугаар А/147

Бат-Өлзий сум

Үер усны аюулаас үүссэн нөхцөл
байдлын талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.12 дахь залтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт үер усны улмаас үүссэн нөхцөл байдлыг арилгах, нөхөн сэргээх ажлыг хариуцан зохион байгуулахыг Засаг даргын орлогч (Н.Орхонтуул)-д даалгасугай.

2. Үер усны аюулын улмаас эвдэрсэн гол горхи, гүүрүүдэд тэмдэг тэмдэглэгээг яаралтай хугацаанд хийж байршуулахыг Засаг дарга Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ), Цагдаагийн тасгийн дарга, (Цагдаагийн хошууч Д.Энх-Амгалан) нарт даалгасугай.

3. Үерт өртөх өндөр магадлалтай айл өрхүүдэд албан мэдэгдэл хүргүүлж, албадан нүүлгэх арга хэмжээ авч ажиллахыг багийн Засаг дарга (Ж.Нямтогтох, Д.Бямбасүрэн, С.Төмөр, Г.Пүрэвтогтох, Г.Бямбагарав, Д.Дэмиддагва) нарт үүрэг болгосугай.

4. Ариутгал халдваргүйжүүлэлтийн баг томилон ажиллуулахыг Эрүүл мэндийн төвийн их эмч (Б.Ганням)-д үүрэг болгосугай.

5. Үерт өртсөн айл өрхүүдийн судалгааг нарийвчлан гаргах, хохирол тогтоох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Янжиндулам (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:
С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)
Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)
И.Маралмаа (Газрын даамал)
Э.Бадамханд (Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)
Э.Дашдулам (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)
Г.Сугар (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мэргэжилтэн)
Б.Энхмаа (Байгаль хамгаалагч)
Г.Ганчимэд (Эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан)


622301301

6. Аялал жуулчлалаар зугаалж яваа гадаад, дотоодын иргэдэд зориулж аюулгүй зорчих аялалын маршрутыг гаргаж, мэдээлэл хүргэж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Орхонтуул), Цагдаагийн тасгийн дарга, (Цагдаагийн хошууч Д.Энх-Амгалан) нарт үүрэг болгосугай.

7. Бүтээн байгуулалтын ажлуудад томилогдсон ажлын хэсгүүд өдөр тутмын гүйцэтгэлийн хяналт тавьж, долоо хоног тутам мэдээ мэдээлэл өгч ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Орхонтуул), Засаг дарга Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ) нарт үүрэг болгосугай.

8. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН